



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 21 өдөр


Дугаар А/192

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9, 3 дугаар хэсгийн 3.1.3, 4 дүгээр хэсгийн 4.4.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн авто зам, замын байгууламж цас мөсийг цэвэрлэх ажлын шаардлагатай материалыг худалдан авах ажлыг 2016 оны 12 дугаар сарын 22-ны дотор зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрийн зам замын байгууламжийг халтиргаа гулгаагүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.
2. Авто зам, замын байгууламж, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цас мөсийг цэвэрлэх ажлын шаардлагатай материалыг худалдан авахад шаардагдах 1,000,000₮ /нэг сая төгрөг/-ийг хот тохижилтын бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Булган/-д зөвшөөрсүгэй.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

